



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/21

Арвайхээр сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө бий болгох, бүртгэх, худалдах, шилжүүлэх журам”-ын 3.13.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2022 оны “Хөрөнгө шийдвэрлэх тухай” 12 дугаар сарын 12-ны өдрийн А/562 дугаар захирамжийн дагуу 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн автомашины дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Ариунаа (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

Гишүүд: Ц.Идэрсайхан (аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Б.Баттөр (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн мэргэжилтэн)

Хөтлөгч: С.Даваадоньд (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

Тэмдэглэл хөтлөгч: Б.Эрдэмзаяа (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газрын Архив, бичиг хэрэг, нярвын ажилтан)

1. Дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг ажлын хэсэг (Г.Ариунаа)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0041